



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/551

Булган сум

**Бүгд Найрамдах Солонгос Улсын Шинхан
Их сургуулийн бакалаврын 2 дугаар курсын оюутнуудын
сургалтын төлбөрт хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны "Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай" IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны "Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай" IV/26 дугаар тогтоол, 2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" VIII/56 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны "Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай" А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Шинхан Их сургуультай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд орон нутгийн тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр аймгийн Засаг даргын нэрэмжит 100 хувийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан, 2023 онд гэрээ байгуулан дүнгийн голч оноо 2.8-аас дээш хангасан, бакалаврын 2 дугаар курст элсэн суралцаж байгаа оюутнуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоход шаардлагатай 83,063,700 (наян гурван сая жаран гурван мянга долоо зуу) төгрөг, гадаад гуйвуулгын төлбөрт 160,000 (нэг зуун жаран мянга) төгрөгийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ГҮРЭВ-ОЧИР



Булган Аймаг 2025 оны 08 сарын 19 өдөр /2025/08/19

6325010760

Аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 19-ий өдрийн 55/ дугаар захирамжийн хавсралт



Бүгд Найрамдах Солонгос Улсын Шинхан Их сургуулийн бакалаврын 2 дугаар курст дүнгийн голч оноо 2.8-аас дээш элсэж, Булган аймгаас 100 хувийн тэтгэлэгтэй суралцах оюутнуудын жагсаалт

№	Сум , сургууль	Овог нэр	Нэр	Мэргэжил	Сургалтын төлбөр /төгрөг/
1	Булган	Батжаргал	Бавуудорж	Программ хангамж	9,326,310
2	Булган	Цогтмагнай	Түвшинжаргал	Программ хангамж	7,993,980
3	Бугат	Баасандорж	Хүслэн	Программ хангамж	7,993,980
4	Дашинчилэн	Батсүх	Адьяахүү	Шүдний техник судлал	7,609,500
5	Сэлэнгэ	Батчулуун	Долгион	Олон улсын аялал жуулчлалын менежмент	6,279,840
6	Сайхан	Наранцэцэг	Оюунбилэг	Программ хангамж	9,326,310
7	Хангал	Ууганбаатар	Ураноо	Төрийн захиргаа	6,279,840
8	Хангал	Лхамсүрэн	Наранчимэг	Сувилахуй	6,274,500
9	Хялганат	Эрдэнэпил	Содбуян	Төрийн захиргаа	6,279,840
10	Могод	Пүрэвжаргал	Эмүүжин	Аялал жуулчлал	5,233,200
11	Рашаант	Цэрэнтогтох	Наранцэцэг	Олон улсын аялал жуулчлалын менежмент	10,466,400
НИЙТ ДҮН					83,063,700

Монгол банкны 2025 оны 08 дугаар сарын 18-ны ханш 1KRW - 2.59 төгрөг